

МОНГОЛЫН ИЛЧЛЭН ШҮҮМЖЛЭХ НИЙТЛЭЛ ДЭХ  
ЖИГҮҮРТЭН "СУРВАЛЖЛАГЧИД"-ЫН АСУУДАЛД

Л. Норовсүрэн\*

\* МУИС, НШУС. Сэтгүүл зүйн тэнхмийн багш, шинжлэх ухааны доктор, профессор.

**Түлхүүр үг:** сэтгүүл зүй дэх илчлэн шүүмжлэх чиглэл, иргэнлэг сэтгэл, ингүүн егөө, үглэн гомдоллох, хошин шог зохиолын уламжлал.

**М**онголын ард түмэн "бурууд нүд хурц" хэмээн хэлэлцдэг нь нийгмийн дунд тогтсон хэв ёс, төрийн хууль цааз, эх орон, ард түмний эрх ашигт харшилсан аливаа сөрөг үзэгдэл, үйлдэлд шүүмжлэлтэй хандаж ирсэн эртний уламжлалтай холбоотой юм. Манай аман болоод бичгийн утга зохиол, ардын сурган хүмүүжүүлэх ухаанд хар хорын сэтгэл, ховдог шунахай зан, харгис хэрцгий авирыг шоглон шүүмжилсэн зүйл арвин байдаг.

Гэвч өнгөрсөн түүхийн туршид оршиж ирсэн нийгэм-улс төрийн тогтолцооноос шалтгаалан утга зохиолын илчлэн шүүмжлэх чиглэлийг ил шууд хөгжүүлэх бололцоо хязгаарлагдмал буюу заримдаа бүр хаалттай байжээ. Ийм үед ард түмэн амаа хамхиж суусангүй, харин ч шудрага бус явдалтай тэмцэх уран арга ухаан сэдэж, гэм дутагдлыг үгэн сумаар ниргэсээр байсан юм. Тэр цагт үнэнч шудрага нь ялагдаж, зусарч бялдууч нь завшдаг байсан бурангуй тогтолцоог манай бичгийн мэргэд тэсч ядан шүүмжилсэн байдаг. Тэдгээр хүмүүс амьдарч асан цаг үеийнхээ түүхийг бүтээх нийтлэлчийн байнгын үйл хэрэгт

татагдан орж, иргэнлэг сэтгэлийн гал дөлөөр бусармаг явдалтай тэмцэж байсныг нь Д.Данзанравжаагийн хэлсэн "Чин үнэн сэтгэл минь орчлонтой таардаггүй", Ц.Ишсамбуугийн хэлсэн "Үзэхийн эн өчүүхэн тэнэг та нар өчүүхэн худгийн яст мэлхийг намтрыг барьсан мөн", Д.Шагдарын хэлсэн "Энэрэлгүй арьяавал авралгүй болжээ, эрх барьсан ноёд хуульгүй болжээ" гэсэн үгс тодорхой харуулдаг.

Манай ард түмэн дээдсийн бурангуй явдлыг илчлэхийн тулд "Далан худалч", "Бэлэн Сэнгэ" мэтийн гүйлгээ ухаантай, энгүүн егөөтэй хүмүүсийг санаанаасаа зохион амьдруулж, шудрага бусын эсрэг тэмцэлдүүлж ирсэн нь санамсаргүй хэрэг биш байлаа. Түүнчлэн шудрага бус явдал, муйхар тулгалтын өмнө хүч мөхөсдсөн адгуусан амьтан, эд юмс амь орж, дээдэстэй мөчөөрхөн сөргөх, үглэн гомдоллох зэргээр бурууг илчилж, зөвийг эрэлхийлж байдаг нь ч бас л шудрага үг хаалттай байсны илрэл мөн.

Ийнхүү зохиогчид халгүйгээр үнэн хурц шүүмжлэлийг өрнүүлэх бас нэг уран аргыг ардын билэгтнүүд эрж олсон нь илчлэн шүүмжлэх нийтлэлд жигүүртэн шувуудыг ашигласан явдал мөн.

Монголын бичгийн мэргэд жигүүртнийг зохиол, нийтлэлд ашиглахдаа юуны өмнө шувуудын өвөрмөц онцлог, ааш араншин, амьдралын

хэв маягийг танин мэдсэний үндсэн дээр сонгож хэрэглэдэг байжээ.

Энэхүү сонголтын үр дүнд тоть, тоншуул, хөхөө, шаазгай, бялзуухай, хэрээ, ангир, галуу, элээ, болжмор, тагтаа зэрэг шувууд уран зохиол, нийтлэлд гол баатар, үзэгч, мэдээлэгч, сурвалжлагч, шүүмжлэгч болж оролцох нь элбэг байдаг.

Жигүүртнийг нийтлэлд ашиглахдаа тэдгээрээс гардаг дуу авианы байдал, үйл үйлдлийн шинжийг зохиол, нийтлэлийн агуулгад тохируулахыг эрхэмлэдэг байсан нь хоёрдахь онцлог юм. Манай ард түмэн хөхөөг дууч, шаазгайг ховч, тотийг дуурайн давтагч, тоншуулыг ниргэн устгагч, хэрээг муу хэл дамжуулагч, галууг аядуу зөөлний илч, тагтааг энхийн бэлгэдэл, болжморыг шулганан жиргэгч, элээг энэрэнгүй үйлстэн, бялзуухайг бядан явагч, ангирыг лам шувуу гэх мэтээр тодорхойлж, тэр онцлогийг нь харгалзан зохиол, нийтлэлийн баатар буюу үзэгч мэдээлэгч болгодог байна. Тухайлбал хэрээ дуугарвал өлзий бус явдал болох буюу хаа нэгтээ сэг зэм гарсны шинж гэж үздэг. Өвөг дээдэс маань хэрээ дуугарахад "Сайн хэл, сайн хэл. Сайн хэл наашаа, муу хэл цаашаа" хэмээн шившдэг нь дээрх үзэлтэй холбоотой юм. Түүнчлэн элээг хүнд ойр байдаг, хал балгүй амьтан гэж үздэг нь эртнээс буй болсон үзэл ажээ.

Эртний Миссир улсын үсгийн зурагт оцойн суусан элээ шувууны дүрсийг "ээж", "эх" гэж утгачилдаг

байсны учир нь элээ шувуу хоол тэжээл хомс болоход өөрийн биеийг шалбалж цус гаргаад төрсөн үрээ тэжээдэг туйлын энэрэнгүй, асрамжтай амьтан болохыг бэлгэдсэн хэрэг юм. Манай малчин ардууд гэр дээрээс элээ аарц шүүрэх, хүүхдийн гараас гүзээ, зайдас зэргийг булаах мэтэд төдий л их ундууцдаггүй, бараг л ёстой юм ёсоороо болж байна гэх нь холгүй байдаг нь мөн л дээрхээс үүдэлтэй ажээ.

Өөр нэг сонирхолтой зүйл бол илчлэн шүүмжлэх нийтлэлд яагаад заавал шувуудыг сонгож ашигласан бэ гэдэг асуудал юм. Энэ нь юуны өмнө шувуудын мэдээлэл дамжуулах онцгой чадвартай холбоотой байна.

Шувуудыг хэрэг явдлын гэрч, үзэгч, мэдээлэгч бол-

«

*Манай ард түмэн хөхөөг дууч,  
шаазгайг ховч, тотийг дуурайн  
давтагч, тоншуулыг ниргэн устгагч,  
хэрээг муу хэл дамжуулагч, галууг  
аядуу зөөлний илч, тагтааг энхийн  
бэлгэдэл, болжморыг шулганан  
жиргэгч, элээг энэрэнгүй үйлстэн,  
бялзуухайг бядан явагч, ангирыг лам  
шувуу гэх мэтээр тодорхойлж, тэр  
онцлогийг нь харгалзан зохиол,  
нийтлэлийн баатар буюу үзэгч  
мэдээлэгч болгодог байна.*

»

гох хэд хэдэн дөхөмтэй тал байгаа нь нэгдүгээрт: нисдэг амьтан тул цаг хэмнэж мэдээллийн шуурхай байдлыг хангаж чаддаг, хоёрдугаарт: өндөрт дүүлж умбан нисдэг тул зам зуурын элдэв саадтай тулгарч мэдээ занги үрэгдэх магадлал бага, гуравдугаарт: асар хурдтай жигүүртэн учраас аливаа мэдээллийн эх сурвалжид цаг алдалгүй нэвтрэх чадвартай, дөрөвдүгээрт: янз бүрийн дуу авиа гаргаж, үзсэн харсан зүйлээ мэдээлэх бололцоотой зэрэг болно. Ерөөсөө шувууны мэдээлэл зөөж дамжуулах онцгой чадварыг үнэлэх явдал эртний уламжлалтай юм. Эртний Перс, Скифийн дайны үед

скиф нараас Дарий хаанд шувуу, хулгана, мэлхийний хамт 5 ширхэг сүм илгээснийг Дарий хааны утга тайлагч түшмэл Гобрий гэгч "Та шувуу болж тэнгэрт халин ниссэн ч, хулгана болж газарт шурган орсон ч, мэлхий шиг усанд шумбасан ч манай сумнаас зайлж чадахгүй" хэмээн тайлсан тухай домог бий. Үүнээс үзсэн ч шувууг хүний эрхшээлд оруулах нь санааны зоргоор бүтэх ажил биш байна.

Монголчууд эрт цагаас гадагш илгээх захидлынхаа дугуй дээр шувуу зурж "нис нис" хэмээн бичдэг байсан, өөрсдөө шувуу шиг дүүлэн нисэхийг ямагт мөрөөдөж, далавч хийж туршиж үзсэн, үлгэр туульсдаа нисдэг морь, гуурст хүлэг мэтийн дүрийг бүтээн хэлэлцдэг зэрэг нь шувууны онцгой шинжийг мэдэж эрхэмлэсний гэрч болох юм.

**Ж**игүүртнийг нийтлэлд ашиглах болсон бас нэг шалтгаан нь зохиогч-хүнийг орлуулах хэрэгцээнээс үүдэлтэй байна. Нийгэм тэнгэр язгуурт дээдэс, муу заяат боол зарц, эсвэл эрх мэдэлтэн, энгийн ард гэсэн анги ялгаварт хуваагдаж, тэгш бус байдал ноёрхсон газарт үнэн үг, шудрага шүүмжлэл хориотой байдаг. Тийм цагт гарт баригдаж, нүдэнд үзэгдэхгүй алсад нисэн оддог жигүүртэн шувуугаар тэрхүү хориотой үгийг хэлүүлэх нь нэн тохиромжтой байжээ.

Монголын илчлэн шүүмжлэх нийтлэлд шувуудыг ашигласан нэлээд түрүү үеийн жишээ нь XVII-XVIII зууны үед бүтээлээ туурвиж байсан Зая бандид Сунтарын Лувсанпэрэнлэйн "Хөх толгойт хөхөө шувууны яруу өгүүлэл" гэдэг сургаалын шүлэглэлт нийтлэлийг нэрлэж болно. Лувсанпэрэнлэй уг нийтлэлдээ тухайн үеийн нийгэмд хуралдсан бурангуй явдал, дээдэс доодсын

ялгаа, шудрага бус байдлыг илчлэн шүүмжилж, ийм байдлаас гарах зөв зам бол эрдэм номыг амьдралын үндсэн зорилго, улс орны хөгжил дэвшлийн тулгуур үндэс хөгжил явдал мөн гэсэн дэвшилт болгох илэрхийлсэн ажээ.

Ер нь манай эртний бичгийн мэргэд хөхөө шувууг яруу сайхны бэлгэдэл, сайхан цагийн эхлэл гэж бэлэгшээдэг, тиймээс уран яруу өгүүлсэн зүйлийг хөхөөн дуутай адилтгаж, яруу байдлыг үр нөлөөний чухал хөшүүрэг гэж үздэг байжээ. Шижээ гавж XIX зууны тэнцэшгүй их ачит язгуур лам, үнэн утгын их мэргэн З.Агваанбалдан хэмээх алдартын эрдмийг өгүүлэхийн үүднээс магтсан яруу үгсээ "Хаврын хөхөөн дуу" гэж нэрлэсэн, Д.Данзанравжаа алдарт жүжгийн зохиолдоо "Саран хөхөөний намтар" гэдэг нэр хайрласан, Л.Агваанхайдав "Үг утга нь тодорхой цадиг" хэмээх бүтээлдээ хөхөөг "хаврын элч", хөхөө донгодохыг "таван эгшиг" гээд ном зохиолоор эрдэм ухааныг түгээж, үнэн шудрагыг номлох нь уран хөхөө донгодож сэтгэлийг уяраахтай адил гэсэн зэргээс үзэхэд хөхөөг сайн үйлсийн мэдээ дамжуулагч, яруу дуугаараа сэтгэлийг уяраагч хэмээн бэлэгшээдэг байсныг мэдэж болно.

Зая бандид Лувсанпэрэнлэй нэгэн бүтээлдээ өөрийн туурвил зохиол, үзэл үйлдэлдээ дүгнэлт хийж "Шүтээн минь тойны авиртай ч шүүрсэн зовлонт хар хүний үйлстэн, дуугарах хэл минь номыг өгүүлэвч дуурайн дуугарах тотийн уншлага мэт" гэсэн байдаг. Энд тоть шувууны дуу нь сэтгэлээс төрөгдсөн ухамсарт үйлдэл бус зөвхөн дуу авиаг давтан өгүүлсэн хуулбар мөн гэсэн санаа агуулагджээ. Хожим үед тухайлбал хувьсгалт нийтлэл үүсч хөгжих явцад энэ үзэл санааг өргөн ашиглаж "Тоть шувууны сургааль", "Уран тотийн

өгүүлэл" гэх мэт шүүмжлэлт нийтлэл, байнгын булан тогтмол хэвлэлүүдэд хэвшсэн байв. Тоть шувуу дуу авиаг дуурайн давтдаг тул хэн нэг хүний зохисгүй үйлдэл, хэлсэн үгийг түүний үгээр хэлүүлэх нь хэрэв явдлын үнэн магадтай болохыг баталгаажуулах нэг арга, хуучин уран зохиолын уламжлал байжээ.

Монголын илчлэн шүүмжлэх нийтлэлд шашныг шинэтгэх үзэл бүхий хурц шүүмжлэлийн эхийг тавьсан хүний нэг нь Цахар гэвш Лувсанчүлтэм юм. Түүний зохиол бүтээлд Монголын бурхны шашны нийгмийн зөрчлийн шалтгааныг нээн харуулж, лам хуврагууд ёс жаягаа гажуудуулж, яс чанараа гэжж байгааг илчлэн шүүмжилсэн зүйл олон байна. Тухайлбал "Агваанринченд сургасан сургааль" гэдэг шүлэглэлт нийтлэлдээ:

"Эдүгээ цагийн олонх ард оюун хийгээд

Эртний буян турханы тул цөв болсны эрхээр

Эрхэм мэргэдээс ч эгэл тэнэг хүндтэй болсон тул

Эгнэгт сайтар номловч бусдад туслах нь бэрх ажээ" гэсэн байдаг.

Тэрбээр бас "Үнэхээр эрдэм алиныг ч сурч үл болох тойдыг үзэмжтэй сайхан болговч тойнд тооцох хэрэггүй, хэзээд үйл үрийг бодож тоолох хэрэгтэй буй заа. Хэрэггүй мэнгэ суудал тоолох нь юуны хэрэг, хэзээд туст үйлийг үйлдэх хэрэгтэй буй заа" гээд "Үүр цайхад үүдэн дэх нохой улих нь муу ёр бус, үүр цайхад тойн хүн согтоод уйлах нь чухам муу ёр. Үдэш эр тахиа хашгирах нь муу ёр бус, үдэш тойн хүн согтоод хашгирах нь чухам муу ёр. Харанхуй шөнө дунд агт морь янцгаах нь муу ёр бус, харанхуй шөнө дунд тойн хүн хурьцлыг үйлдэх нь чухам муу ёр"

хэмээн сахил санваараа зөрчсөн лам нарыг шүүмжилж байв.

Лувсанчүлтэм эрдэм ухаанд гэгээрсэн сэтгэгч хүний хувьд байгаль нийгмийн амьдралын зарим асуудлыг цаг үеэсээ үлэмж түрүүлэн харж байсан байдал мэдрэгддэг. Түүний нийтлэлийн бүтээлд нийгмийн бурангуй ёс, зан суртахууны дутагдлыг илчлэхийн хамт аливаа өөдрөг зөв үзлийг дэмжиж, оюун ухаан, эрдэм номын хүчээр олон нийтийг гэгээрүүлж буяны үйл бүтээхийг уриалан дуудсан агуулгатай зүйл зонхилж байлаа. Түүнчлэн дээр дооргүй эрүүл саруул орчин бүрдүүлж, хүнлэг ариун ёс суртахуун бүхий тэгш эрхт харилцааг зөгнөн мөрөөдөж, нийгмийн хэт их ялгарал нь атаархах, дайсагналцах шалтгаан болж байгааг зааж байв. Тухайлбал "Дээр өндөр болбоос атаархах, доор бага болбоос доромжлон муушаах. Дээрээ ноён үгүй бөгөөд доороо боол үгүй, дэргэдээ дайсангүй тул алгасал бүхнээс ангижирсан, дээдийн номын үйлийг үргэлж өөрийн дураар үйлдэхийн дээд, тийм нэгэн сайхан цаг хэзээ нэгэн бүрдэх бол" гэсэн нь ардчиллын чухал шалгуурын нэг болох тэгш эрхийн тухай санааг одоогоос хоёр зуугаад жилийн тэртээ дэвшүүлэн тавьсан хэрэг байна.

Говийн ноён хутагт Д.Данзан-равжаа (1804-1856) "Арга барилын цогц" хэмээх бүтээлдээ "Үзлийн муу өрнөсөн ийм хачин цагт үнэн үгтэн омогтны тоонд орно, башир үгтэн сэцний суудалд сууна. Үнэн шудрага өгүүлэгч хүн цагаан хэрээ, үнэнч ариун явдалтан нь муушаалын орон, аяа маш уйтгартай ч орон юм даа" хэмээн гаслан бичиж байсан нь өнөөдөр ч ач холбогдлоо алдаагүй байна. Тэрбээр шашин бурхан хийгээд ариун шудрага үйлсийг худал хуурмагийн хар

сүүдэр дайрч, нийгэм хөл толгойгоо олохоо байсныг харамсан бичихдээ:

"Ачит эх болсон амьтны зовлон Ахуй орчлонгийн нэн хуурамч-

хан байдал

Алдарт Мунийн шашны дорой-  
тол

Энэ гурвыг санахад голоосоо гашуудна" ("Аврал бүхэн хурсан") гэж бичээд эхэс дээдсээсээ эхлээд энгийн ардаа хүртэл нийгэм бүхлээрээ ёс суртахууны уналтад орж, шудрага ёс орхигдоход хүрсэн нь ард олны гай зовлон, нийгмийн зөрчлийн үндэс болж байгааг зохиол бүтээлдээ илэрхийлж байв. Тухайлбал "Цагийн жамыг тодруулагч цаасан шувуу" зохиолдоо "Энэ цагийн аглагч ноёд, идэгч түшмэд, хариу бодогч өглөгийн эзэд, тэмцэлдэгч ардаас эхлэн ертөнц ба номын зүг гэвч суудлын төлөө олох нэр, эдийн төлөө номлох ном, алдрын төлөө үйлдэх буян, омгийн төлөө шүтэх шавь тэргүүтэн муу явдлыг өөрсдөө үйлдээд цагийн муу гэнэ" гэхчилэн муу цагийн гамшиг буюу нийгмийн хямрал задралын шалтгааныг хүний өөрийнх нь ёс суртахуунтай холбож үзсэн байдаг. Гэтэл тэр шудрага бусын эсрэг хийсэн үгэн тэмцлийнхээ төлөө ихэс дээдэс, мяндаг тушаалтнуудад адлагдан хавчигдаж, "галзуу, солиот" нэр зүүж яваад цаг бусаар хальсан байдаг. Энэ нь мөн л нийтлэл зохиолд зохиогчийн нэрийг нууцлах, амьтан ба эд юмс өгүүлсэн болгох шаардлагыг төрүүлж байсан хэрэг юм.

XIX зуун бол Монголын утга зохиолын дотроос нийтлэлч шинж ялгаран гарч, ялангуяа илчлэн шүүмжлэх чиглэл эрс өссөн үе байв. Академич Д.Дамдинсүрэн энэ тухай өгүүлэхдээ "XVIII зууны орчмоос монгол зохиолын дотор шашны догматик номлолд шүүмжлэлтэй хандах, ихэс дээдсийг шүүмжлэх, иргэний зохиолд сонирхлоо хандуулах ийм дэвшилттэй гурван урсгал гарч, XIX зууны үе болоход бүр хүчтэй болж ирсэн юм"<sup>1</sup> гэсэн бол бүтээлийнхээ өөр нэг хэсэгт "Тэдгэ-

рийн дотор хос ёсны сургаалын шүлэг, яруу найргийн онол, уран хэлээр бичсэн намтар, түүх, уран домог, уран зохиолын товёог, шүүмжлэл, өгүүллэг нэлээд байна"<sup>2</sup> гэжээ. Үүнээс үзвэл илчлэн

«

*Д.Данзанравжаа, Ц.Ишсамбуу,  
Д.Шагдар, Л.Агваанхайдав, хуульч  
Сандаг нарын "Үг" зохиолын  
уламжлалыг XX зууны эхэн үеийн  
хувьсгалт нийтлэл, уран зохиолд  
Г.Навааннамжил, С.Буяннэмэх,  
Д.Чимэд, М.Ядамсүрэн, Г.Занабазар  
нар шинэ нөхцөлд тохируулан  
ашигласан байдаг.*

»

шүүмжлэх явдал утга зохиолын бие даасан зүйл болж төлөвшсөн байжээ.

XIX зууны үеийн нийгмийн ялзрал доройтол, харийн дарлалын тэсвэрлэшгүй байдал нь эрдэмт мэргэдийн үзэл бодолтой зөрчилдөж, тэднээс нийгмийн бурангуй, шудрага бус байдлыг илчлэхдээ хэрэглэх бас нэг аргыг олсон нь "Үг" зохиол юм. Д.Данзанравжаа, Ц.Ишсамбуу, Д.Шагдар, Л.Агваанхайдав, хуульч Сандаг нарын "Үг" зохиолын уламжлалыг XX зууны эхэн үеийн хувьсгалт нийтлэл, уран зохиолд Г.Навааннамжил, С.Буяннэмэх, Д.Чимэд, М.Ядамсүрэн, Г.Занабазар нар шинэ нөхцөлд тохируулан ашигласан байдаг.

Г.Навааннамжил хуучин уран зохиолын шог хошин төрлийн уламжлалыг хувьсгалт хэвлэлийн нийтлэлд шинэчлэн хөгжүүлэх зорилгоор 1928 онд өөрөө санаачилсан "Бядан явагч бялзуухай миний өгүүлэл" гэдэг булан нээж, шинэ нийгмийн үйл хэрэг, ёс сурталд харшилсан сөрөг үзэгдлийг шүүмжилж байжээ. Уг булан Монголын тогтмол хэвлэлд 60 шахам жил хадгалагдаж сонин уншигчдын хэд хэдэн үеийнхнийг хүмүүжүүлсэн юм. М.Ядамсүрэнгийн "Анхаарч биширсэн чавганц, атаархан хорссон лам хоёрын байдал", Д.Чимэдийн "Сонин үлгэр", "Ангир шувуу", Занабазарын "Таван цогцос харилцан тэмцсэн үлгэр", Шагдарсүрэнгийн "Жинст огдой", М.Ядамсүрэнгийн "Ухваргүй ярилцаан", С.Буяннэмэхийн "Том жижиг тугалган үсгийн маргаан", Чинбатын "Бийр, харандаа, үзэг гуравын үлгэр" зэрэг олон бүтээлд "Үг" зохиолын уламжлалыг ашиглажээ.

**И**лчлэн шүүмжлэгч нийтлэлд жигүүртнийг ашиглах уламжлал ер тасалдаагүй байна. Гучаад оны сонин сэтгүүлд тоть шувууны үгээр аливаа дутагдал хоцрогдлыг илчилдэг байв. "Уран тотийн өгүүлэл" буланг хэд хэдэн сонин сэтгүүл тогтмол хөтөлж байлаа.

Түүнийг залгаад тоншуул гарч иржээ. Ийм нэртэй сэтгүүлийн эх суурь 1935 онд тавигдсанаас хойш өнөөдрийг хүртэл гарч шог хошин нийтлэл, зураасан зургийн арвин санг бүрдүүлсэн юм. Тоншуул өнгөрсөн хугацаанд манай хэвлэл мэдээллийн "домогт сурвалжлагч", олон нийтийн "сайн нөхөр" болж чадсан юм.

Түүний "нэр хүнд"-ийг радио, телевизэд ашиглаж "Тоншуулын

толинд" гэдэг шүүмжлэлт нэвтрүүлэг хөтөлж байлаа.

Шүүмжлэлт нийтлэлд жигүүртнийг ашиглах уламжлал одоо ч тасраагүй байна. Гэхдээ хувьсгалын ихэн үеийнх шиг шүүмжлүүлэгчийн мөрдөлтөөс зохиогчийг нуух хэрэгцээгээр биш, шувуудын өвөрмөц шинжийн талаарх хүмүүсийн ойлголтоор дамжуулан тэдэнд мэдээллийг сонирхолтой, үр нөлөөтэй хүргэх зорилгоор ашигладаг болжээ.

Дал, наяд оноос Монголын радиод хөтөлж эхэлсэн "Болжморын жиргээ", "Шаазгайн шагшраа" гэх мэт нэвтрүлэгт нэр бүхий шувуудын хүнд хүрч нөлөөлөх онцлогийг оновчтой бодож олсон учраас сонсогчдын сонирхолд нийцэж байсан юм.

Ийнхүү жигүүртэн шувуудын хурдан дэвэлт, хурц хараа, дуу авиаг дутагдал зөрчлийг олж илрүүлэх, няцаан шүүмжлэх хэрэгсэл болгон ашиглаж ирсэн нь Монголын ард түмний үлгэр домгийн сэтгэлгээнээс улбаатай бөгөөд утга зохиол дахь илчлэн шүүмжлэгч чиглэлийн үндэсний өвөрмөц онцлогийн нэг мөн.

## Ишлэл

<sup>1</sup> 1987. Монголын уран зохиолын өв уламжлал. УБ. 205 дахь тал.

<sup>2</sup> Мөн зох. 203 дахь тал.

## Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Гаадамба Ш, Сампилдэндэв Х. 1988. Монгол ардын аман зохиол. УБ.

2. Дамдинсүрэн Ц. 1987. Монголын уран зохиолын өв уламжлалын асуудалд. УБ.
3. Дамдинсүрэн Ц. 1957. Монголын уран зохиолын тойм. I боть. УБ.
4. Жүгдэр Ч. 1978. Агваанбалдангийн гүн ухааны үзэл. УБ.
5. Жүгдэр Ч. 1972. XIX-XX зууны заагдахь Монголын нийгэм-улс төр, философийн сэтгэлгээний хөгжил. УБ.
6. Норовсүрэн Л. 2004. Монголын нийтлэл. УБ.
7. Норовсүрэн Л. 2000. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. (Тэргүүн боть). УБ.

## Resume

In this article, it is recounted about how the tradition of the ancient mongolian literature to reveal social deficiencies through personified animals and objects has been inherited and used in the modern journalism. Of these, the method to write personifying birds who are specifically suitable for transferring and expressing information into a main hero, spectator, informer or interviewer, has been considered here extensively, using various type examples and evidences.